

## **Тэмбүү, өвчтөний мэдээлэл (2016-10-21)**

Халдвар хамгааллын эмч нарын халдвар хамгааллын хуудас.

### **Танд яагаад энэ мэдээллийг өгсөн бэ?**

Та тэмбүүний халдвар авсан эсвэл авсан байх магадлалтай. Энэ хуудсанд тэмбүү, үүнийг хэрхэн эмчлэх ба та юу хийх шаардлагатай талаар мэдээлэл бий.

### **Тэмбүү гэж юу вэ?**

Тэмбүү нь шээсний сүв, үтрээ ба шулуун гэдэсний салст бүрхэвчид голдуу суудаг бактери юм. Бактери мөн цусанд байж болно. Хүн олон жил тэмбүүг мэдэхгүйгээр тээж болно.

### **Яаж тэмбүүтэй болдог вэ?**

Тэмбүү голдуу хамгаалалтгүй бэлгийн харьцаа буюу үтрээ эсвэл шулуун гэдэсний хавьталтаар, мөн амын бэлгийн харьцаагаар дамжина. Эх жирэмсэн үедээ хүүхэддээ халдаах магадлалтай.

Тэмбүү хувцас, алчуур эсвэл жорлонгоор дамжихгүй, учир нь бактери биеээс гадуур амьдрах чадваргүй. Тэмбүүний халдварыг хүн хэд хэдэн удаа авч болно.

### **Тэмбүүтэй болсноо хүн мэдэх үү?**

Ихэнх халдвар авсан хүмүүст шинж тэмдэг илэрдэггүй. Өөрөөр хэлбэл хүн өөрийгээ халдвартай гэдгийг анзаардаггүй.

Зарим хүмүүс бэлэг эрхтэн дээр эсвэл тэр хавьд, амандаа эсвэл шулуун гэдэсдээ шархтай болдог. Ийм шарх ихэнхдээ хэдэн долоо хоногийн дараа эдгэрдэг. Зарим хүмүүсийн биен дээр, мөн голдуу алганд мөн хөлийн уланд юм туурдаг.

Ямар нэгэн шинж тэмдэг байхгүй ч тэмбүү маш амархан халдварлах чадвартай.

### **Тэмбүү аюултай юу?**

Эмчлэхгүй бол тэмбүү бүх биенд ноцтой гэмтэл өгөх аюултай.

### **Тэмбүүг хэрхэн эмчлэх вэ?**

Тэмбүүг антибиотикоор (тариа эсвэл эм) эмчилнэ. Та эмээ зааврын дагуу хэрэглэж танд өгсөн зөвлөгөөг дагавал халдвар арилна. Эмчилгээ үнэгүй.

Танд эргэж ирэх цаг өгсөн бол та заавал очих ёстой. Халдвар арилсан эсэхийг шалгах зорилгоор шинэ шинжилгээ авах шаардлагатай байж болно.

Та тэмбүүтэй бол хүнд халдаах эрсдэл авч болохгүй. Эмч таныг эмчлэгдсэн гэж хэлтэл та бусадтай хавьтах эсвэл өөр төрлийн бэлгийн харьцаанд орохгүй байх нь баталгаатай. Та бэлгийн харьцаанд орвол нөгөө хүндээ өөрийгөө тэмбүүтэйг хэлж, мөн хамгаалалт (бэлгэвч) хэрэглэх ёстой.

### **Шинжилгээгээр би тэмбүүтэй байсан нь харагдах уу?**

Та дараа тэмбүүний шинжилгээ өгвөл тэмбүүтэй байсан нь заавал харагдана. Тэр үед өөр төрлийн шинжилгээгээр та дахиад тэмбүүний халдвар авсан эсэх нь мэдэгдэнэ.

### **Халдвар мөрдөлт - энэ юу вэ?**

Тэмбүүтэй хүмүүсийг олж, эмчлэх нь маш чухал, ингэснээр нэгд, гэмтэл (дээр дурдсан) авах, хоёрт, халдвар улам олон хүмүүст тарах эрсдэл багасах юм.

Та тэмбүүтэй бол халдвар мөрдөгчид өөрийн хавьтсан / бэлгийн харьцаанд орсон (заримдаа сүүлийн нэг жилийн хугацаанд) хүн / хүмүүсийг хэн гэдгийг хэлэх ёстой.

Таны халдвар мөрдөгчид хэлсэн зүйл нууц (нууцлал), мөн таны мэдээлсэн хүмүүс таныг гэж мэдэхгүй. Тэд зөвхөн өөрсдийгөө шинжлүүлэх шаардлагатай гэдгийг л сонсоно.

### **Тэмбүү Халдвараас хамгаалах хуульд байдаг - энэ юу гэсэн үг вэ?**

Халдвараас хамгаалах хуульд тэмбүү мэт өвчнийг зогсоож бусдад тараахгүйн тулд мөрдөх дүрэм журам бий. Тэмбүүтэй эсвэл тийм байх магадлалтай хүн өөрийн эмчийн өгсөн дараах дүрэм журмыг дагах ёстой:

- Эмч танд эргэж ирэх цаг өгсөн бол та заавал очих ёстой.
- Чи өөрийн бэлгийн харьцаанд орох хүнд өөрийгөө тэмбүүтэй эсвэл тийм байх магадлалтай гэдгийг хэлэх ёстой.
- Та өөрийн эмчилгээ / шинжилгээг дуустал бэлгийн харьцаанд орвол хамгаалалт хэрэглэх ёстой.

Та өөрт өгсөн мөрдөх журмыг буруу гэж үзэж байвал, та харьяаллын эмнэлгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

### **Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?**

Тэмбүүний талаарх нэмэлт мэдээллийг дараах цахим хуудсаас уншиж болно.

[www.1177.se](http://www.1177.se)

[www.folkhalsomyndigheten.se](http://www.folkhalsomyndigheten.se)

[www.umo.se](http://www.umo.se) (интернет дах өсвөр үеийнхэн залуучуудын хүлээн авах эмнэлэг)

### **Сайн дурын мэдээллийн цонх (*frivillig informationsruta*)**

Та дараах хүмүүстэй уулзсан (*Du har träffat*)

.....

Халдвар мөрдөлтийн захиалсан цаг (*Smittspårning bokad datum*)

.....

Дараагийн давтан цаг (*Nästa återbesök*)

.....

Хүлээн авах эмнэлгийн утас / утасны цаг (*Telefonnummer/telefonid till mottagningen*)

.....